# УЛААНБААТАР ХОТЫН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН БОЛОН АРИЛЖААНЫ ТЕЛЕВИЗҮҮДЭЭР 2021, 2022 ОНД НЭВТРҮҮЛСЭН ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ АНАЛИТИК ТАЙЛАН

## Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтийн байдал, үр нөлөө

### *Оршил*

Энэхүү тайланд Улаанбаатар хотод тусгай зөвшөөрөлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа өргөн нэвтрүүлгийн 18 (Монгол улсад хамрах хүрээтэй), арилжааны 48 телевизийн (тусгай зөвшөөрөлтэй 55 телевизээс) 2021, 2022 онд нэвтрүүлсэн зар сурталчилгааны тайлан мэдээг нэгтгэн хүргэж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30.1.8-д заасан эрх, чиг үүргийн дагуу телевизүүдийн хөтөлбөрт байнгын хяналт, мониторинг хийж ажилладаг бөгөөд Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлага, Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтийн байдлаар сар, улирал бүр тайлан мэдээ гаргаж, өөрийн цахим хуудсаар тогтмол мэдээлэн ажиллаж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журмын хэрэгжилтийн байдалд хийсэн дэлгэрэнгүй тайлан, мониторингийн дүн мэдээлэлд шинжилгээ хийж, Улаанбаатар хотын телевизүүдээр нэвтрүүлсэн зар сурталчилгааны хэмжээ, хугацаа, судалгааны тайланг гаргалаа.

Энэхүү тайлангаар телевизээр нэвтрүүлсэн зар сурталчилгааг телевизийн тусгай зөвшөөрлийн ангилал бүрээр тухайлбал өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевиз тус бүрээр гаргаж, 2021, 2022 онд цацсан нийт зар сурталчилгааны хэмжээ, нийт зар сурталчилгаанд эзэлсэн нийгмийн зар сурталчилгаа, оргил цагийн сурталчилгаа болон арилжаа сурталчилгааны нэвтрүүлгийн хувь хэмжээ, зар сурталчилгааны хэтрэлтийн дүн мэдээ зэрэг үзүүлэлтүүдээр анализ хийж гаргалаа.

Улаанбаатар хотын өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр 2021 онд 7605:29:51 цагийн арилжааны реклам, сурталчилгаа цацсан бол 2022 онд 7561:58:13 цаг болж 0.6%-иар буурсан боловч нийт телевизүүдийн арилжааны сурталчилгаанд эзлэх хувь хэмжээ 3%-иар өссөн, арилжааны 48 телевизээр 2021 онд 8955:53:54 цаг цацсан бол 2022 онд 7765:37:10 цаг болж 13.2 %-иар буурсан, нийт нийт телевизүүдийн арилжааны сурталчилгаанд эзлэх хувь хэмжээ мөн 3%-иар буурсан үзүүлэлттэй байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нийт 66 телевизээр 2022 онд нийт 15327:35:23 цагийн арилжааны зар сурталчилгаа цацсан бол үүний 49%-ийг өргөн нэвтрүүлгийн телевизүүд, 51%-ийг арилжааны телевизүүд цацсан, нийлбэр дүнг 2021 онтой харьцуулахад 7.4%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Харин нийгмийн шинжтэй зар сурталчилгааг авч үзэхэд өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр 2021 онд 1319:01:26 цаг, 2022 онд 694:35:32 цаг цацаж телевизүүдээр цацсан нийт нийгмийн сурталчилгаанд эзлэх хувь 5%-иар буурсан бол арилжааны телевизүүдээр 2021 онд 2263:32:24 цаг, 2022 онд 1496:23:44 цаг цацаж буурсан үзүүлэлттэй байгаа ч нийт телевизүүдээр цацсан нийгмийн сурталчилгаанд эзлэх хувь 5 %-иар өссөн байна.

1. ***Телевизүүдээр (өргөн нэвтрүүлгийн болон арилжааны )нэвтрүүлсэн зар сурталчилгааны хэмжээ.***

Телевизүүдийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн дүнгээс нийт телевизүүдийн 2021, 2022 оны жилийн нийт эфирийн цагт нэвтрүүлсэн зар сурталчилгааны хувь хэмжээг телевизийн төрлөөр авч үзэхэд:

| Төрөл | Нийт зар сурталчилгаа | 2021 | | | 2022 | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Секунд | Цаг:мин:сек | Хувь | Секунд | Цаг:мин:сек | Хувь |
| ӨНТВ | Нийгмийн зар сурталчилгаа | 4,748,486 | 1319:01:26 | 15% | 2,500,532 | 694:35:32 | 8% |
| | Арилжааны зар сурталчилгаа | 27,379,791 | 7605:29:51 | 85% | 27,223,193 | 7561:58:13 | 92% |
| Арилжааны телевизүүд | Нийгмийн зар сурталчилгаа | 8,148,744 | 2263:32:24 | 20% | 5,387,024 | 1496:23:44 | 16% |
| | Арилжааны зар сурталчилгаа | 32,241,234 | 8955:53:54 | 80% | 27,956,230 | 7765:37:10 | 84% |

Нийт телевизүүдээр цацсан зар сурталчилгаанд эзлэх нийгмийн болон арилжааны зар сурталчилгааны хувь хэмжээг телевизийн төрлөөр авч үзэхэд.

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| ӨНТВ | Нийгмийн зар сурталчилгаа | 4,748,486 | 7% | 2,500,532 | 4% |
| | Арилжааны зар сурталчилгаа | 27,379,791 | 38% | 27,223,193 | 43% |
| Арилжааны телевизүүд | Нийгмийн зар сурталчилгаа | 8,148,744 | 11% | 5,387,024 | 9% |
| | Арилжааны зар сурталчилгаа | 32,241,234 | 44% | 27,956,230 | 44% |
| Нийт телевизээр цацсан зар сурталчилгааны хэмжээ | | 72,518,255 | | 63,066,979 | |

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд:

- 2021 онд өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр цацсан нийт зар сурталчилгаанд нийгмийн зар сурталчилгаа 15% эзлэж байсан байсан бол 2022 оны байдлаар 8%-д нэвтрүүлсэн байна.
- Харин 2021 онд нийт телевизүүдээр нэвтрүүлсэн зар сурталчилгаанд өргөн нэвтрүүлгийн 18 телевизээр цацсан нийгмийн зар сурталчилгаа 7 %, арилжааны 48 телевизээр цацсан нийгмийн зар сурталчилгаа 11 % эзлэж байсан бол энэ

хувь хэмжээ 2022 онд өргөн нэвтрүүлгийн телевизээр 4%, арилжааны телевизээр 9 % болж буурсан үзүүлэлттэй байна.

- Нийт телевизээр цацсан зар сурталчилгаанд эзлэх арилжааны зар сурталчилгааг (реклам, сурталчилгаа) авч үзэхэд өргөн нэвтрүүлгийн телевизээр 38%, арилжааны телевизүүдээр цацсан нь 44 %-ийг эзлэж байгаа бөгөөд 2022 онд өргөн нэвтрүүлгийн телевизүүдээр цацсан арилжааны зар сурталчилгааны хэмжээ 156,598 сек-р буурсан ч нийт зар сурталчилгаанд эзлэх хувь хэмжээг нь авч үзэхэд 5%-иар өссөн харагдаж байна.

Арилжааны телевизүүдийн зар сурталчилгаа нэвтрүүлсэн хувь хэмжээг авч үзэхэд:

Нийгмийн зар сурталчилгаа нь арилжааны телевизүүдийн цацсан нийт зар сурталчилгаанд 2021 онд 20%, 2022 онд – 16 % болж буурсан бол, нийт телевизүүдийн зар сурталчилгаанд эзлэх хувь хэмжээг авч үзэхэд 2021 онд 11 % эзлэж байсан бол 2022 онд 9% болж мөн буурсан үзүүлэлттэй байна.

Арилжааны зар сурталчилгааг нийт телевизүүдийн зар сурталчилгаанд эзлэх хувиар авч үзэхэд 2021, 2022 онд тогтвортой 44%-тай байна. Гэвч арилжааны зар сурталчилгаа цацсан цагийг авч үзэхэд 2022 онд буурсан үзүүлэлттэй байна.

***-Нийгмийн зар сурталчилгаа***

| Төрөл | 2021 | | | 2022 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Секунд | Цаг:мин:сек | Хувь | Секунд | Цаг:мин:сек | Хувь |
| ӨНТВ-18 | 4,748,486 | 1319:01:26 | 37% | 2,500,532 | 694:35:32 | 32% |
| Арилжааны телевизүүд-48 | 8,148,744 | 2263:32:24 | 63% | 5,387,024 | 1496:23:44 | 68% |
| Нийт | 12,897,230 | 3582:33:50 | 100% | 7,887,556 | 2190:59:16 | 100% |

*Хүснэгт1:Нийгмийн зар сурталчилгаа цацагдсан хувь, ТВ төрлөөр*




*График 1:Нийгмийн зар сурталчилгаа цацагдсан хувь-ТВ төрлөөр*

- Нийт телевизээр цацсан нийгмийн зар сурталчилгаанд өргөн нэвтрүүлгийн телевизээр цацсан нийгмийн зар сурталчилгаа 37% эзэлж байсан бол 2022 оны байдлаар 32% болж буурсан байна.
- Харин арилжааны телевизүүдийн хувьд нийгмийн зар сурталчилгаа 2021 онд нийт телевизүүдийн цацсан нийгмийн зар сурталчилгаанд 63% эзэлж байсан бол 2022 оны байдлаар 68%-д цацсан байна.

***Арилжааны зар сурталчилгаа***

| Төрөл | 2021 | | | 2022 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Секунд | Цаг:мин:сек | Хувь | Секунд | Цаг:мин:сек | Хувь |
| ӨНТВ-18 | 27,379,791 | 7605:29:51 | 46% | 27,223,193 | 7561:58:13 | 49% |
| Арилжааны телевизүүд-48 | 32,241,234 | 8955:53:54 | 54% | 27,956,230 | 7765:37:10 | 51% |
| Нийт | 59,621,025 | 16561:23:45 | 100% | 55,179,423 | 15327:35:23 | 100% |

*Хүснэгт 2-Арилжааны зар сурталчилгаа цацагдсан хувь, ТВ төрлөөр*

*Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд:*

- Арилжааны зар сурталчилгаа нь 2022 онд 2021 оноос 44 цагаар буурсан үзүүлэлтэй боловч нийгмийн зар сурталчилгааны хэмжээ 5%-иар буурсан учир нийт зар сурталчилгааны цагт эзлэж байгаа арилжааны зар сурталчилгааны хувь хэмжээ өсөлттэй харагдаж байна.

*Арилжааны телевизүүдийн хувьд:*

- Арилжааны зар сурталчилгааны цагийг авч үзвэл 2022 онд 2021 оноос 1190 цагаар буюу -3% буурсан үзүүлэлтэй байгаа ч нийгмийн зар сурталчилгааны цаг багассан учраас нийт зар сурталчилгаанд эзлэх хувийг авч үзэхэд өссөн үзүүлэлттэй харагдаж байна:




*График 2:Арилжааны зар сурталчилгаа цацагдсан хувь-ТВ төрлөөр*

- ***Өргөн нэвтрүүлгийн телевиз тус бүрээр***

| ***ӨНТВ*** | ***2021 он*** | | ***2022 он*** | |
|---|---|---|---|---|
| | ***Секунд/цагаар*** | | ***Секунд/цагаар*** | |
| Сүлд | 162825 | 45:13:45 | 278357 | 77:19:17 |
| Тэнгэр | 986914 | 274:08:34 | 346546 | 96:15:46 |
| Стар ТВ | 775597 | 215:26:37 | 821319 | 228:08:39 |
| TM | 1592160 | 442:16:00 | 938432 | 260:40:32 |
| C1 | 1527111 | 424:11:51 | 953889 | 264:58:09 |
| Монгол HD | 992689 | 275:44:49 | 1068577 | 296:49:37 |
| Central ТВ | 995214 | 276:26:54 | 1216094 | 337:48:14 |
| ТВ8 | 1637329 | 454:48:49 | 1314101 | 365:01:41 |
| ЕТВ | 2620057 | 727:47:37 | 1433070 | 398:04:30 |
| SBN | 1273284 | 353:41:24 | 1595120 | 443:05:20 |
| Ийгл ньюс | 1349005 | 374:43:25 | 1676358 | 465:39:18 |
| UBS | 1300001 | 361:06:41 | 1874140 | 520:35:40 |
| ТВ9 | 1734595 | 481:49:55 | 1914618 | 531:50:18 |
| ТВ5 | 1924758 | 534:39:18 | 1917840 | 532:44:00 |
| 25-р суваг | 1533191 | 425:53:11 | 1948349 | 541:12:29 |
| Боловсрол суваг | 2143887 | 595:31:27 | 2417569 | 671:32:49 |
| NTV | 2511611 | 697:40:11 | 2694095 | 748:21:35 |
| Малчин ТВ | 2319563 | 644:19:23 | 2814619 | 781:50:19 |
| *Нийт цаг* | 27379791 | **7605:29:51** | 27223093 | **7561:58:13** |

*Хүснэгт 3-Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн нэвтрүүлсэн арилжааны зар сурталчилгааны үзүүлэлт 2021,2022 цаг/секунд*




*График 3:Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн арилжаа сурталчилгаа нэвтрүүлсэн цаг- телевиз тус бүрээр*

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн арилжааны зар сурталчилгааны нэвтрүүлсэн 2021, 2022 оны 16744 цагийг харьцуулж харахад **Central, Монгол HD, SBN, Ийгл ньюс, UBS, ТВ9, 25-р суваг, Боловсрол, NTV, Малчин** телевизүүдийн зар сурталчилгааны цаг өссөн үзүүлэлттэй байна.




*График 4:Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн арилжаа сурталчилгааны нэвтрүүлсэн хэмжээ сараар /2021,2022/*

Өргөн нэвтрүүлгийн 18 телевизийн нэвтрүүлсэн 2021, 2022 оны арилжаа сурталчилгааны цагийг 1-12 сараар нэгтгэн үзэхэд 2022 онд өмнөх оноос 1-5 болон 11-12 саруудад зар сурталчилгааны цаг өссөн үзүүлэлтэй байна.




*График 4:Цагийн анализ-Өргөн нэвтрүүлгийн телевиз*

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн реклам цацалтыг цагаар анализ хийн авч үзэхэд 2022 онд оргил цаг буюу 19-20, 21-22, 23-00 цагуудад зар сурталчилгааны цаг өссөн үзүүлэлтэй харагдаж байна.

- ***Арилжааны телевизүүд***

| ***Арилжааны ТВ*** | ***2021 он*** | | ***2022 он*** | |
|---|---|---|---|---|
| Бидний цөөхөн Монголчууд | 0 | 0:00:00 | 0 | 0:00:00 |
| C Channel | 1773 | 0:29:33 | 260 | 0:04:20 |
| Mon Plus | 0 | 0:00:00 | 768 | 0:12:48 |
| Нийслэл | 0 | 0:00:00 | 11531 | 3:12:11 |
| Trade | 0 | 0:00:00 | 17708 | 4:55:08 |
| ТВ3 | 62671 | 17:24:31 | 28986 | 8:03:06 |
| ТВ2 | 17364 | 4:49:24 | 29222 | 8:07:02 |
| Лайк ТВ | 55857 | 15:30:57 | 34064 | 9:27:44 |
| National times news | 214857 | 59:40:57 | 72594 | 20:09:54 |
| Их Засаг | 0 | 0:00:00 | 73937 | 20:32:17 |
| Парламент | 52368 | 14:32:48 | 81278 | 22:34:38 |
| GTV | 49660 | 13:47:40 | 88172 | 24:29:32 |
| Скай ТВ | 424481 | 117:54:41 | 91322 | 25:22:02 |
| Соён гэгээрүүлэгч | 191137 | 53:05:37 | 137975 | 38:19:35 |
| ОНТВ | 466406 | 129:33:26 | 155914 | 43:18:34 |
| Volume Plus | 12485 | 3:28:05 | 220575 | 61:16:15 |
| Лайв ТВ | 413418 | 114:50:18 | 326967 | 90:49:27 |
| MNC | 454277 | 126:11:17 | 403446 | 112:04:06 |
| Royal | 1915048 | 531:57:28 | 427711 | 118:48:31 |
| ТВ6 | 510505 | 141:48:25 | 432488 | 120:08:08 |
| Малчин Бирж ТВ | 947338 | 263:08:58 | 486336 | 135:05:36 |
| Channel 11 | 384075 | 106:41:15 | 538190 | 149:29:50 |
| Авто ТВ | 875034 | 243:03:54 | 558005 | 155:00:05 |
| News Channel | 887411 | 246:30:11 | 572821 | 159:07:01 |
| Bloomberg MN | 1122685 | 311:51:25 | 667160 | 185:19:20 |
| Суваг 1 | 888019 | 246:40:19 | 677459 | 188:10:59 |
| Глобаль ТВ | 51859 | 14:24:19 | 750620 | 208:30:20 |
| Мянгат Малчин ТВ | 2763023 | 767:30:23 | 967205 | 268:40:05 |
| Суваг 7 | 1190364 | 330:39:24 | 1064298 | 295:38:18 |
| Талын Монгол | 900365 | 250:06:05 | 1131524 | 314:18:44 |
| Өлзий ТВ | 2186199 | 607:16:39 | 1578008 | 438:20:08 |
| ОТВ | 1817910 | 504:58:30 | 1623331 | 450:55:31 |
| Масс ТВ | 2196277 | 610:04:37 | 1849360 | 513:42:40 |
| Эко | 1692057 | 470:00:57 | 1958732 | 544:05:32 |
| нийт/цаг | 22744923 | ***6318:02:03*** | 17057967 | ***4738:19:27*** |

*Хүснэгт 4-Арилжааны телевизүүдийн нэвтрүүлсэн арилжааны зар сурталчилгааны үзүүлэлт 2021,2022 цаг/секунд*

Арилжааны телевизүүдийн арилжааны зар сурталчилгааны нэвтрүүлсэн цагийг 2021, 2022 онтой харьцуулж харахад **Channel 11, Талын монгол, Эко, Volume plus, Глобал** телевизүүдийн зар сурталчилгааны цаг өссөн үзүүлэлттэй байна.




*График 5:Арилжаа сурталчилгааны цаг-жилээр/2021,2022/*

- ***Төрөлжсөн телевизүүд***

| *Төрөлжсөн* | *2021 он* | | *2022 он* | |
|---|---|---|---|---|
| Хөгжим | 238 | 0:03:58 | 0 | 0:00:00 |
| SPS NBA | 0 | 0:00:00 | 69486 | 19:18:06 |
| Скай TV | 0 | 0:00:00 | 76179 | 21:09:39 |
| SPS Classic | 73862 | 20:31:02 | 115040 | 31:57:20 |
| SPS Fight | 168384 | 46:46:24 | 145986 | 40:33:06 |
| Cinema | 36667 | 10:11:07 | 151800 | 42:10:00 |
| Movie Max | 542780 | 150:46:20 | 210841 | 58:34:01 |
| М кино | 0 | 0:00:00 | 250662 | 69:37:42 |
| SPS National | 524843 | 145:47:23 | 339408 | 94:16:48 |
| SPS World | 28141 | 7:49:01 | 459089 | 127:31:29 |
| SPS Prime | 1228968 | 341:22:48 | 842777 | 234:06:17 |
| Asia box | 2004730 | 556:52:10 | 2568108 | 713:21:48 |
| Movie Box | 2453208 | 681:26:48 | 2773542 | 770:25:42 |
| Dream TV | 2434490 | 676:14:50 | 2980813 | 828:00:13 |
| *нийт цаг* | 9496311 | **2637:51:51** | 10983731 | **3051:02:11** |

*Хүснэгт 5-Төрөлжсөн телевизүүдийн нэвтрүүлсэн арилжааны зар сурталчилгааны үзүүлэлт 2021,2022 цаг/секунд*

Төрөлжсөн телевизүүдийн арилжааны зар сурталчилгааны нэвтрүүлсэн цагийг 2021, 2022 онтой харьцуулж харахад 2022 онд 414 цагаар өссөн байгаа нь **SPS Classic, Cinema, М кино, SPS World, Asianbox, Movie box, Dream TV** телевизүүдийн зар сурталчилгааны цаг өссөн үзүүлэлттэй байна.




*График 6:Төрөлжсөн телевизүүдийн арилжаа сурталчилгааны цаг-жилээр/2021,2022/*




*График 7:Төрөлжсөн телевизүүдийн арилжаа сурталчилгааны цаг-сараар/2021,2022/*

Төрөлжсөн телевизүүдийн арилжаа сурталчилгааны цагийг сараар нэгтгэн үзэхэд 2022 онд 12 сараас бусад сарууд өмнөх оноосоо өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

| Төрөлжсөн | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2021 он | 722436 | 728472 | 819277 | 768535 | 873848 | 784197 | 806624 | 652607 | 622342 | 756422 | 878957 | 1082594 |
| 2022 он | 1023312 | 936239 | 1109830 | 848609 | 945423 | 796846 | 910967 | 764842 | 900031 | 919090 | 911108 | 917434 |




*График 8: Арилжааны телевизүүдийн арилжаа сурталчилгааны цаг-сараар/2021,2022/*

Арилжааны болон төрөлжсөн телевизүүдийн зар сурталчилгааг сараар нэгтгэн үзэхэд 2022 онд 2021 онтой харьцуулахад зар сурталчилгаа буурсан үзүүлэлттэй, ялангуяа 6,7,8-р саруудад өмнөх оноосоо зар сурталчилгааны нийлүүлэлт илүү багассан харагдаж байна.

2022 оны нэгдсэн мониторингийн дүнгээс харахад хамгийн их сурталчилгаа 3, 5, 11, 12 саруудад нийлүүлэгдсэн байхад 7, 8 саруудад сурталчилгаа хамгийн бага нийлүүлэгджээ.




*График 9:Арилжааны телевизүүдийн реклам цацалтын цагийн анализ*

Арилжааны телевизүүдийн реклам цацалтыг цагаар анализ хийн авч үзэхэд 2022 онд оргил цаг буюу 17-22, 23-00 цагуудад зар сурталчилгааны цаг өссөн үзүүлэлтэй харагдаж байна.

2022 онд цацагдсан зар сурталчилгааны хэмжээг цагаар нь авч үзвэл оройн 19-23 цагт хамгийн их зар сурталчилгаа цацагджээ.

## *2.Нэг цагт дамжуулах зар сурталчилгааны 15 минутын хэтрэлт*

**Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам:**

*4.13. Өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизээр нэвтрүүлж буй зар сурталчилгааны хугацааг тогтоох, үүнд: "1 цагт дамжуулах зар сурталчилгаа 15 минутаас хэтрэхгүй байх" заалтыг хангасан байдал.*

| Үзүүлэлт | 2021 | | | 2022 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Секундээр | Цаг:мин:сек | хувь | Секундээр | Цаг:мин:сек | хувь |
| Нийт сурталчилгааны хэмжээ | 59,621,025 | 16561:23:45 | 98% | 55,179,423 | 15327:37:03 | 98% |
| Хязгаараас хэтэрсэн дүн | 1,207,171 | 335:19:31 | 2% | 1,002,886 | 278:34:46 | 2% |

*Хүснэгт 6-Нийт телевизүүдийн зар сурталчилгааны хэмжээ-2021,2022 цаг/секунд*

Өргөн нэвтрүүлгийн болон арилжааны телевизүүдийн зар сурталчилгааны хэмжээнээс харахад (нийгмийн зар сурталчилгаа ороогүй) 2021 онд 16561 цагийн зар сурталчилгаанаас 335 цагийн хэтрэлттэй байсан бол 2022 онд 15327 цагийн зар сурталчилгаанаас 278 цагийн хэтрэлттэй, хэтрэлтийн хувь хэмжээг 2021 онтой харьцуулахад 2% хэвээр байгаа хэдий ч 57 цагаар буурсан үзүүлэлтэй харагдаж байна.

### *Өргөн нэвтрүүлгийн телевизүүд*

| **ӨНТВ** | ***2021 он*** | | ***2022 он*** | |
|---|---|---|---|---|
| Стар ТВ | 25730 | 7:08:50 | 0 | 0:00:00 |
| Сүлд | 494 | 0:08:14 | 57 | 0:00:57 |
| ТВ8 | 25731 | 7:08:51 | 83 | 0:01:23 |
| Монгол HD | 185 | 0:03:05 | 552 | 0:09:12 |
| VTV (Хуучин) | 17309 | 4:48:29 | 690 | 0:11:30 |
| ТМ | 26621 | 7:23:41 | 1442 | 0:24:02 |
| Ийгл ньюс | 14484 | 4:01:24 | 2244 | 0:37:24 |
| Central ТВ | 2741 | 0:45:41 | 2848 | 0:47:28 |
| SBN | 45510 | 12:38:30 | 4367 | 1:12:47 |
| ЕТВ | 177377 | 49:16:17 | 6655 | 1:50:55 |
| C1 | 11765 | 3:16:05 | 7027 | 1:57:07 |
| 25-р суваг | 12817 | 3:33:37 | 28540 | 7:55:40 |
| UBS | 42930 | 11:55:30 | 33354 | 9:15:54 |
| Боловсрол суваг | 62692 | 17:24:52 | 40348 | 11:12:28 |
| ТВ9 | 53486 | 14:51:26 | 51935 | 14:25:35 |
| ТВ5 | 46995 | 13:03:15 | 80094 | 22:14:54 |
| NTV | 169168 | 46:59:28 | 119105 | 33:05:05 |
| Малчин ТВ | 23910 | 6:38:30 | 343082 | 95:18:02 |

| нийт цаг | 759945 | 211:05:45 | 722423 | 200:40:23 |
|---|---|---|---|---|

*Хүснэгт 7-ӨНТВ-үүдийн зар сурталчилгааны хэтрэлт 2021,2022/цаг, секунд/*

2021 онд өргөн нэвтрүүлгийн 18 телевизүүдийн зар сурталчилгааны хэтрэлтийг **ETV, NTV, Боловсрол** телевизүүдийн хэтрэлт өндөр байсан бол 2022 онд зөрчлөө бууруулсан үзүүлэлттэй байгаач зөрчлөө арилгаагүй байна. 2022 онд **Малчин,TV5, NTV** телевиз өндөр хэтрэлттэй байгаагаас өмнөс жилээсээ хэтрэлт нь өссөн байна. Мөн 25-р суваг телевизүүд хэтрэлтийн зөрчлөө арилгаагүй өссөн үзүүлэлттэй байна.




*График 10: Нэг цагт дамжуулах 15 минутын хэтрэлт-ӨНТВ*

| ӨНТВ | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2021 он** | 25153 | 26277 | 30328 | 30464 | 49306 | 40343 | 197945 | 167525 | 37516 | 39974 | 47789 | 67325 | 759945 | 211:05:45 |
| | **3.31%** | **3.45%** | **4.01%** | **4.00%** | **6.47%** | **5.29%** | **25.98%** | **22.00%** | **4.92%** | **5.25%** | **6.27%** | **9.06%** | | |

| ӨНТВ | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2022 он** | 72622 | 85113 | 59544 | 24731 | 38641 | 56181 | 55978 | 65066 | 53055 | 58406 | 71056 | 82030 | 722423 | 200:40:23 |
| | **10.05%** | **11.78%** | **8.24%** | **3.42%** | **5.35%** | **7.78%** | **7.75%** | **9.01%** | **7.34%** | **8.08%** | **9.84%** | **11.35%** | | |
| | | | | | | | | | | | | | **-4.94%** | |

*Хүснэгт 8-ӨНТВ-үүдийн 2021,2022 онд сар бүр хэтрүүлсэн зар сурталчилгааны хэтрэлтийн хэмжээ/секунд/*




*График 11:Нэг цагт дамжуулах 15 минутын хэтрэлт -ӨНТВ /сараар/*

2021 онд өргөн нэвтрүүлгийн 18 телевизийн зар сурталчилгааны 15 минутын хэтрэлтийг 12 сарын нийлбэр дүнгээр авч үзэхэд нийт 211 цаг байсан бол 2022 онд 200 цаг болж -5% буурсан үзүүлэлттэй байна. Сараар авч үзэхэд 2021 онд 7-8 сарууд 26% хүртэлх зар сурталчилгааны хэтрэлттэй байсан бол 2022 онд хамгийн өндөр хэтрэлт нь 11% болж бууруулсан үзүүлэлттэй байна. 7-8-р сард өмнөх онтой харьцуулахад 25%-иас 8% болж буурч -17%-иар зар сурталчилгааны хэтрэлт буурсан харагдаж байна.

- ***Арилжааны телевизүүд***

| ***Арилжааны телевизүүд*** | ***2021 он*** | | ***2022 он*** | |
|---|---|---|---|---|
| News Channel | 7710 | 2:08:30 | 782 | 0:13:02 |
| Глобаль ТВ | 0 | 0:00:00 | 1574 | 0:26:14 |
| ОТВ | 12184 | 3:23:04 | 3685 | 1:01:25 |
| Эко | 18583 | 5:09:43 | 5910 | 1:38:30 |
| Талын Монгол | 824 | 0:13:44 | 18657 | 5:10:57 |
| Мянгат Малчин ТВ | 276024 | 76:40:24 | 26507 | 7:21:47 |
| Малчин Бирж ТВ/Их засаг/ | 17729 | 4:55:29 | 34383 | 9:33:03 |
| Өлзий ТВ | 45585 | 12:39:45 | 53608 | 14:53:28 |
| Масс ТВ | 22014 | 6:06:54 | 56590 | 15:43:10 |
| ***нийт цаг*** | 403878 | **112:11:18** | 203243 | **56:27:23** |

*Хүснэгт 9-Арилжааны телевизүүдийн 2021,2022 оны зар сурталчилгааны хэтрэлт/цагсекунд/*

2021 онд арилжааны 32 телевизүүдийн 15 минутын хэтрэлтийн хувьд 12 сарын нийт дүнгээр **Өлзий, Малчин Бирж ТВ/-Их засаг/, Масс ТВ** телевизүүдийн хэтрэлт өндөр байсан бол **Мянгат малчин** телевиз зөрчлөө бууруулж ажилласан ч хэтрэлт байсаар байна. 2022 оны хэтрэлт нь **Их засаг, Өлзий, Масс, Талын монгол** телевизүүдийн зөрчил хэвэндээ өссөн үзүүлэлтэй байсан байна.




*График 12:Арилжааны телевизүүдийн нэг цагт дамжуулах 15 минутын хэтрэлт*

| Артв | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2021 - /31ТВ/ | 33255 | 21418 | 21365 | 27796 | 47996 | 55315 | 40281 | 43848 | 44998 | 37372 | 26022 | 4212 | 403878 | 112:11:18 |
| | 8.23 % | 5.30 % | 5.29 % | 6.88 % | 11.88 % | 13.70 % | 9.97 % | 10.86 % | 11.14 % | 9.25 % | 6.44 % | 1.04 % | | |

| Артв | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | 11 сар | 12 сар | нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2022 - /32ТВ/ | 12665 | 29718 | 39157 | 31297 | 35970 | 7455 | 16980 | 991 | 13592 | 7292 | 3983 | 4143 | 203243 | 56:27:23 |
| | 6.23 % | 14.62 % | 19.27 % | 15.40 % | 17.70 % | 3.67 % | 8.35 % | 0.49 % | 6.69 % | 3.59 % | 1.96 % | 2.04 % | -49.68% | |

*Хүснэгт 10-Арилжааны телевизүүдийн 2021,2022 онд сар бүр хэтрүүлсэн зар сурталчилгааны хэтрэлт /секунд/*

2021 онд арилжааны телевизүүдийн зар сурталчилгааны 15 минутын хэтрэлтийг 12 сарын нийт дүнгээр авч үзэхэд 112 цаг байсан бол 2022 онд 56 цаг болж -49% буурсан үзүүлэлттэй байна. Сараар авч үзэхэд 2021 онд 1,5,6 саруудад 14% хүртэлх зар сурталчилгааны хэтрэлттэй байсан бол 2022 онд хамгийн өндөр хэтрэлттэй сар нь 2-4 саруудад 19% байгаа нь 2021 онтой харьцуулахад тухайн саруудад зар сурталчилгааны хэтрэлт өссөн үзүүлэлт харагдаж байна.




*График 13:Арилжааны телевизүүдийн нэг цагт дамжуулах 15 минутын хэтрэлт/ сараар/*

- ***Төрөлжсөн хөтөлбөртэй телевизүүд***

| ***Төрөлжсөн*** | ***2021 он*** | | ***2022 он*** | |
|---|---|---|---|---|
| SPS Classic | 0 | 0:00:00 | 0 | 0:00:00 |
| SPS Fight | 0 | 0:00:00 | 0 | 0:00:00 |
| SPS National | 776 | 0:12:56 | 0 | 0:00:00 |
| Movie Max | 515 | 0:08:35 | 0 | 0:00:00 |
| Скай ТВ | 127 | 0:02:07 | 0 | 0:00:00 |
| Хөгжим | 0 | 0:00:00 | 0 | 0:00:00 |
| SPS World | 0 | 0:00:00 | 795 | 0:13:15 |
| SPS Prime | 3312 | 0:55:12 | 2678 | 0:44:38 |
| Asiabox | 6183 | 1:43:03 | 18727 | 5:12:07 |
| Movie Box | 18873 | 5:14:33 | 24439 | 6:47:19 |
| Dream TV | 13562 | 3:46:02 | 30581 | 8:29:41 |
| ***Нийт цаг*** | 43348 | **12:02:28** | 77220 | **21:27:00** |

*Хүснэгт 11 -Төрөлжсөн телевизүүдийн нэг цагт дамжуулсан зар сурталчилгааны хэтрэлт, цагаар*




*График 14:Төрөлжсөн телевизүүдийн нэг цагт дамжуулах 15 минутын хэтрэлт*

2021 онд төрөлжсөн телевизүүдийн 15 минутын хэтрэлтийн хувьд 12 сарын нийт дүнгээр 12 цаг байгаа нь Asianbox, Moviebox, Dream tv телевизүүдийн хэтрэлт хамаарч байсан бол 2022 онд хэтрэлт өссөн зөрчил мөн хэвэндээ байсан байна.

| Телевизийн төрөл | 2021 | | | 2022 | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Нийт хэтрүүлж цацсан рекламны секунд | Эзлэх хувь | ТВ тоо | Нийт хэтрүүлж цацсан рекламны секунд | Эзлэх хувь | ТВ тоо |
| ӨНТВ | 759,945 **/211 цаг/** | 63% | 18 | 722,423**/200 цаг/** | 72% | 18 |
| АрТВ | 447,226 **/114 цаг/** | 37% | 48 | 280,463**/77 цаг/** | 28% | 51 |
| Нийт | 1,207,171 | 100% | 71 | 1,002,886 | 100% | 74 |

*Хүснэгт 12 -Телевизүүдийн нэг цагт дамжуулсан зар сурталчилгааны хэтрэлт, цагаар*

2022 оны мониторингийн нэгдсэн дүнгээр нийт зар сурталчилгааны цацалт өмнөх оныхоос буурч, хэтрүүлсэн цацсан зар сурталчилгааны хэмжээ нийтэд нь авч үзэхэд мөн адил буурсан үзүүлэлттэй байна. 2021 онд цаг тутам хэтрүүлж цацсан нийт 1,207,171 секундын рекламны 63%-ийг ӨНТВ, 37%-ийг арилжааны телевиз эзэлж байна. 2022 оны зар сурталчилгааны хэтрэлтийн хэмжээг 2021 оны дүнтэй харьцуулбал 204,285 секундээр буурсан үзүүлэлттэй байна. ӨНТВ-ийн хувьд өмнөх онтой харьцуулахад 2% буюу 37522 секундээр буурч, арилжааны телевизийн хувьд 22% буюу 166,763 секунтээр буурчээ.

2022 онд мониторинг хийгдсэн нийт телевизүүдээр 55,179,423**/хүснэгт-2/** секундын арилжааны зар сурталчилгаа (үгэн зарыг тооцсон ба нийгмийн сурталчилгаа ороогүй) цацагджээ. Үүний 1,002,886 зар сурталчилгааг цагт 15 минут байх тогтоосон хугацаанаас хэтрүүлэн цацсан байна.

Зар сурталчилгааг тогтоосон хугацаанаас хэтрүүлэн цацсан саруудад 1, 2, 3, 12 сарууд багтсан бол 4 болон 6 саруудад зар сурталчилгааны хэтрүүлэн цацсан хэмжээ харьцангуй бага үзүүлэлттэй гарсан байна.

Өргөн нэвтрүүлгийн 18 телевиз бүгд зар сурталчилгааны хэтрэлттэй **/хүснэгт-7/** арилжааны телевизүүдээс 26 нь огт хэтрүүлээгүй, 17 суваг нь зар сурталчилгааны хэтрэлттэй гэж гарсан байна.

### *3.Зар сурталтчилгааны нэг блокийн үргэлжлэх хугацаа 5 минутаас илүүгүй байх шаардлагын биелэлт*

*- Өргөн нэвтрүүлгийн телевизүүд*

| Блок-ӨНТВ | 2022 он | |
|---|---|---|
| Монгол HD | 687 | 0:11:27 |
| Стар ТВ | 2900 | 0:48:20 |
| ТВ8 | 3442 | 0:57:22 |
| Тэнгэр ТВ | 4006 | 1:06:46 |
| Сүлд | 6145 | 1:42:25 |
| ТМ | 7493 | 2:04:53 |
| Ийгл ньюс | 26669 | 7:24:29 |
| С1 | 26859 | 7:27:39 |
| SBN | 28989 | 8:03:09 |
| Central ТВ | 30200 | 8:23:20 |
| ЕТВ | 42877 | 11:54:37 |
| Боловсрол суваг | 54559 | 15:09:19 |
| 25-р суваг | 69209 | 19:13:29 |
| ТВ5 | 84648 | 23:30:48 |
| ТВ9 | 134454 | 37:20:54 |

| | | |
|---|---|---|
| UBS | 152396 | 42:19:56 |
| NTV | 168493 | 46:48:13 |
| Малчин ТВ | 728994 | 202:29:54 |

Хүснэгт 12:ӨНТВ-үүдийн блокны хэтрэлтийн хэмжээ/2022 он/




*График 15:ӨНТВ-блок хэтрэлт /2022 он/*

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн блокны хэтрэлтийг 2022 оны байдлаар авч үзэхэд хамгийн өндөр хэтрэлтэй байгаа нь ТВ9, UBS, NTV, Малчин телевизүүд байгаагаас Малчин телевизийн блок 202 цаг буюу сард дунджаар 17 цагийн блокны зөрчлийг гаргасан байгаа нь үгэн зар, цаг агаар, зар сурталчилгааны рекламыг блокоос хэтрүүлж гаргадаг байна.




*График 16:ӨНТВ-блок хэтрэлт /2022 он сараар/*

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд зар сурталчилгааг тогтоосон хугацаанаас хэтрүүлэн цацсан сарууд дундаас хамгийн өндөр хэтрэлттэй сар нь 1,2,12 сарууд багтсан бол 4 болон 5 сарууддад зар сурталчилгааны хэтрүүлэн цацсан хэмжээ бусад саруудаас харьцангуй бага үзүүлэлттэй гарсан байна.

*- Арилжааны телевизүүд*

| Артв-Блок | 2022 он | |
|---|---|---|
| Trade | 15 | 0:00:15 |
| Соён гэгээрүүлэгч | 181 | 0:03:01 |
| Volume Plus | 297 | 0:04:57 |
| ОНТВ | 459 | 0:07:39 |
| National times news | 515 | 0:08:35 |
| Лайк ТВ | 601 | 0:10:01 |
| ТВ2 | 941 | 0:15:41 |
| Royal | 1182 | 0:19:42 |
| Их Засаг | 1709 | 0:28:29 |
| MNC | 1852 | 0:30:52 |
| ТВ6 | 2217 | 0:36:57 |
| SPS World | 3107 | 0:51:47 |
| М кино | 7236 | 2:00:36 |
| Авто ТВ | 8389 | 2:19:49 |
| Cinema | 8662 | 2:24:22 |
| Лайв ТВ | 8714 | 2:25:14 |
| Гандан ТВ | 10120 | 2:48:40 |
| Суваг 7 | 12004 | 3:20:04 |
| SPS Prime | 14654 | 4:04:14 |
| Суваг 1 | 24465 | 6:47:45 |
| Asianbox | 30316 | 8:25:16 |
| Channel 11 | 30964 | 8:36:04 |
| Глобаль ТВ | 34531 | 9:35:31 |
| News Channel | 37389 | 10:23:09 |
| Dream TV | 51946 | 14:25:46 |
| Талын Монгол | 72767 | 20:12:47 |
| Эко | 86825 | 24:07:05 |
| Moviebox | 96788 | 26:53:08 |
| Мянгат Малчин ТВ | 153217 | 42:33:37 |
| Малчин Бирж ТВ/Их засаг/ | 160179 | 44:29:39 |
| ОТВ | 208599 | 57:56:39 |
| Өлзий ТВ | 279749 | 77:42:29 |
| Масс ТВ | 945168 | 262:32:48 |

Хүснэгт 13:Арилжааны телевизүүдийн блокны хэтрэлтийн хэмжээ/2022 он/

Арилжааны телевизүүдийн блокны хэтрэлтийг харахад 2022 онд хамгийн өндөр хэтрэлтэй байсан нь Мянгат малчин ТВ, Их засаг, ОТВ, Өлзий, Масс телевизүүд байгаас Масс телевиз сард 21 цагаар блокны хэтрэлтийг гаргадаг байна. Масс телевизийн блок хэтрэлтийг авч үзвэл үгэн зарыг 15 минутаар нэвтрүүлж блокт боож гаргадаггүйн харагдаж байна.




*График 17:Арилжааны телевизүүдийн блок хэтрэлт /2022 он/*




*График 17:Арилжааны телевизүүдийн блок хэтрэлт /2022 он сараар/*

Зар сурталчилгааг тогтоосон хугацаанаас хэтрүүлэн цацсан саруудад 1, 2, 3, 12 сарууд багтсан бол 4 болон 6 саруудад зар сурталчилгааны хэтрүүлэн цацсан хэмжээ харьцангуй бага үзүүлэлттэй гарсан байна.

**Арилжаа сурталчилгааны нэвтрүүлгийн 15% -ийг хангасан байдал**

| *Өргөн нэвтрүүлгийн телевизүүд* | *Арилжаа сурталчилгааны 15%* | |
|---|---|---|
| | **2021 он** | **2022 он** |
| Монгол HD | 0.27% | 0.18% |
| Боловсрол суваг | 0.28% | 0.28% |
| Ийгл ньюс | 0.29% | 0.23% |
| NTV | 0.58% | 0.51% |
| Central TB | 2.39% | 0% |
| TB9 | 5.13% | 8.12% |
| UBS | 7.01% | 17.65% |
| VTV | 7.64% | 0.06% |
| Сулд | 11.76% | 16.73% |
| 25-р суваг | 13.79% | 12.97% |
| TM | 13.88% | 16.56% |
| Стар ТВ | 14.12% | 18.72% |
| ETB | 15.76% | 13.18% |
| SBN | 15.99% | 20.09% |
| Малчин ТВ | 16.33% | 10.03% |
| TB8 | 16.94% | 12.45% |
| C1 | 16.99% | 11.64% |
| TB5 | 24.74% | 26.59% |

Хүснэгт 14:Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн арилжаа сурталчилгааны 15% хангасан байдал /2022 он/

Телевизээр хоногт нэвтрүүлэх, арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг нь тухайн өдрийн нийт хөтөлбөрийн цагийн 15% илүүгүй байх ба өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн хувьд 2021 онд **ETV, SBN, TB8, Малчин ТВ, C1, TB5** телевизүүд заасан хувь хэмжээнээс хэтрүүлсэн бол 2022 оны байдлаар харахад **SBN, TB5** телевизүүд зөрчлөө арилгаагүй хувь хэмжээ өссөн үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна. Мөн UBS, Сүлд, ТМ, Стар телевизүүд 2021 онд 7%-14% арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн байсан бол 2022 онд 18% хүртэл болж өссөн үзүүлэлтэй харагдаж байна.

| *Арилжааны ТВ* | *Арилжаа сурталчилгааны 15%* | | | | |
|---|---|---|---|---|---|
| ***ТВ нэр*** | 2021 он | 2022 он | ТВ нэр | 2021 он | 2022 он |
| Нийслэл | 0.00% | 12.56% | Малчин Бирж ТВ | 6.45% | 3.33% |
| Лайв ТВ | 0.11% | 13.45% | Талын Монгол | 7.06% | 14.01% |
| Mon Plus | 0.24% | 0.76% | Гандан ТВ | 8.93% | 3.89% |
| National times news | 0.28% | 0.10% | Лайк ТВ | 9.52% | 13.82% |
| Бидний цөөхөн Монголчууд | 0.47% | 0.50% | Royal | 10.02% | 2.84% |
| Парламент | 0.51% | 0.40% | MNC | 11.78% | 19.05% |
| Bloomberg MN | 0.71% | 0.15% | Эко | 16.37% | 14.69% |
| TB6 | 0.98% | 4.35% | Мянгат Малчин ТВ | 16.96% | 12.98% |
| Соён гэгээрүүлэгч | 1.08% | 0.86% | Өлзий ТВ | 19.34% | 18.11% |
| News Channel | 1.73% | 0% | Суваг 1 | 19.99% | 24.14% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Channel 11 | 2.01% | 1.27% | Масс ТВ | 33.10% | 20.72% |
| Авто ТВ | 2.75% | 5.82% | Шууд ТВ | 94.95% | 99.62% |
| Movie Max | 3.30% | 0.25% | Хөгжил ТВ | 98.84% | 68.12% |
| Суваг 7 | 5.86% | 7.30% | Home Shopping | 99.09% | 99.80% |

Хүснэгт 15:Арилжааны телевизүүдийн арилжаа сурталчилгааны 15% хангасан байдал /2022 он/

Телевизээр хоногт нэвтрүүлэх, арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг нь тухайн өдрийн нийт хөтөлбөрийн цагийн 15% илүүгүй байх ба арилжааны телевизүүдийн хувьд 2021 онд **Эко, Мянгат малчин, Өлзий, Суваг 1, Масс** телевизүүд заасан хувь хэмжээнээс хэтрүүлсэн ба 2022 оны байдлаар харахад **Өлзий, Суваг 1, Масс** телевизүүд зөрчлөө арилгаагүй хувь хэмжэээ өссөн үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна. Мөн MNC  телевиз 2021 онд 11% арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн байсан бол 2022 онд 19% болж өссөн үзүүлэлтэй харагдаж байна.